



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/Б22


Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректоратын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-ийн багшийн сонгон шалгаруулалтад орж буй иргэний эрдэм шинжилгээний ажлын түвшинг үнэлэх, дүгнэлт гаргах удирдамж"-ийг хавсралтаар баталж, 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (С.Гомбобаатарт)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425062207

Ректорын 2025 оны 06 дүгээр сарын 21-ны
өдрийн А/322 дугаар тушаалын хавсралт

МУИС-ийн багшийн сонгон шалгаруулалтад орж буй иргэний
эрдэм шинжилгээний ажлын түвшнийг
үнэлэх, дүгнэлт гаргах удирдамж



Нэг. Ерөнхий үндэслэл

Энэхүү удирдамжийг МУИС-ийн Захирлын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/388 тоот тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.16.1 заалт буюу багшийн сонгон шалгаруулалтад орж буй иргэний судалгааны ажлын түвшинд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахад баримтална.

Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, түүний нотлох баримтыг бүрдүүлэх

2.1 МУИС-ийн багшийн сонгон шалгаруулалтад орж буй иргэн эрдэм шинжилгээний бүтээлийг дараах нотлох баримтаар баталгаажуулан Хүний нөөцийн системд бүртгүүлнэ. Үүнд:

2.1.1 Судлаачийн ORCID iD болон h-индекс;

2.1.2 Web of Science болон Scopus-д бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл болон эшлэлийн тоо;

2.1.3 Бусад эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт DOI дугаарын хамт (цахим холбоос оруулах);

2.1.4 Цахим хувилбараар баталгаажаагүй эрдэм шинжилгээний бүтээлийг эх хувь болон эх сурвалжийн нотолгоогоор баталгаажуулан системд бүртгүүлнэ.

Гурав. Эрдэм шинжилгээний түвшнийг үнэлж, дүгнэлт гаргах аргачлал

3.1 МУИС-ийн багшийн сонгон шалгаруулалтад оролцож буй иргэний эрдэм шинжилгээний ажлын түвшин тогтоох оноо нь мэргэжлийн ур чадварын нийт үнэлгээний 30 хувийг эзлэх ба тухайн иргэний харьяалах шинжлэх ухааны салбарын онцлогоос хамааруулан, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 04 тоот тогтоолоор баталсан "МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам"-ын хавсралт 1-ийн 7.1 дүгээр заалтын "Б1. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тооцох багц цаг", 7.2 дугаар заалтын "Б2. Эрдэм шинжилгээний хуралд оролцоход тооцох багц цаг"-т заасан үнэлгээний дагуу доорх байдлаар тооцно. Үүнд:

3.1.1 "Б1. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тооцох багц цаг" хүснэгтэд заасан нийт 27 багц цаг, "Б2. Эрдэм шинжилгээний хуралд оролцоход тооцох багц цаг" хүснэгтэд заасан нийт 23.8 багц цагийг хамгийн бага утга байхаар тооцож, биелүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний ажлын үнэлгээг

“Хангалттай” гэж үзнэ. Үүнд: Өгүүллийн буюу Б1-д заасан багц цагийг бүрэн биелүүлсэн бол 20 оноо, хурлын багц цаг буюу Б2-ыг бүрэн биелүүлсэн бол 10 оноо, нийт 50.8 багц цагийг бүрэн хангасан тохиолдолд бүгд 30 оноогоор тооцно. бүрэн хангасан тохиолдолд бүгд 30 оноогоор тооцно. Жич: Web of Science JCR импакт фактор, Scopus Cite Score бүхий мэргэжлийн Q1-Q4 ангиллын сэтгүүлд (хүснэгтийн Б1.1-р заалт) хэвлүүлсэн бүтээлийн тоогоор нийт 50.8 багц цагийг хангасан тохиолдолд 30 оноогоор тооцно.

3.1.2 Эрдэм шинжилгээний оноо тэнцсэн тохиолдолд шалгаруулалтыг Web of Science болон Scopus-т бүртгэлтэй Q1-Q4 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо, эшлэлийн тоо болон зохиогчийн h-индекс зэрэг судалгааны чанарт тулгуурлан эрэмбэлнэ.

3.1.3 Нэг зохиогчтой нэг сэдэвт бүтээл, нэг сэдэвт хамтын бүтээл, мөн edited book (эмхэтгэсэн хамтын бүтээл)-ийн багц цагийг тооцохдоо дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Web of Science болон Scopus-д бүртгэлтэй хэвлэлийн газраар хэвлүүлсэн тохиолдолд “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”-ын 7.1 дүгээр заалтын Б1.1.1;
- Бусад олон улсын хэвлэлийн газраар хэвлүүлсэн тохиолдолд дээрх журмын Б1.1.2;
- Дотоодын хэвлэлийн газраар хэвлүүлсэн тохиолдолд уг журмын Б1.3-т заасан багц цагийн үнэлгээг тус тус ашиглана.

3.2 Дээд боловсролын тухай хуулийн 15.2 заалтад дээд боловсролын сургалтын байгууллагын багшид магистр, түүнээс дээш зэрэгтэй байх үндсэн шалгууртай тул сонгон шалгаруулалтад орж буй иргэний магистр болон докторын судалгааны ажлыг нэг сэдэвт бүтээл гэж үл тооцно.

3.3 Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг нь тухайн иргэний мэдүүлсэн нотлох баримтгүй эрдэм шинжилгээний бүтээлд оноо тооцохгүй.

3.4 Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад орсон иргэний эрдэм шинжилгээний ажлын түвшнийг ажлын хэсгийн нийт гишүүдийн дундаж оноогоор үнэлж, холбогдох үнэлгээ хийсэн тайлбар, дүгнэлтийг гишүүдийн гарын үсгээр баталгаажуулан Судалгаа, хөгжүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.5 Судалгаа, хөгжүүлэлтийн асуудал хариуцсан нэгж нь сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн үнэлгээ, тайлбар, дүгнэлтийг хянан баталгаажуулж, Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1 Судалгааны түвшний үнэлгээ, дүгнэлт, баталгаажуулалттай холбоотой гомдол, саналыг МУИС-ийн холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.